# “МИК ХОЛДИНГ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 4 сарын 28 өдөр | Дугаар № 17/01 | Улаанбаатар хот

***Компанийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай***

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэг 62.1.9 дэх заалт, Компанийн дүрмийн 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсэг, “МИК Холдинг” ХК-ийн 2017 оны Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 17/04 тоот тогтоолыг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2016 оны үйл ажиллагааны тайлан болон “Эрнст энд Янг Монголия Аудит” ХХК-ийн гаргасан 2016 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх компанийн нэгдсэн санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА — М.МӨНХБААТАР

MIK HOLDING МИК ХОЛДИНГ ХК 1116216038 5221978 УЛААНБААТАР ХОТ

# “МИК ХОЛДИНГ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 4 сарын 28 өдөр Дугаар № 17/02 Улаанбаатар хот

***Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай***

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, 77 дугаар зүйлийн 77.4 дэх хэсэг, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.3.13 дахь заалт, МИК Холдинг ХК-ийн ТУЗ-ийн нэр дэвшүүлэх шагнал урамшууллын хорооны 2017 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн хурлын дүгнэлтийг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ НЬ:**

1. “МИК Холдинг” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнээр дор дурдсан нэр дэвшигчдийг 2018 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэлх хугацаагаар сонгосугай. Үүнд:

   1.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр:

      1.1.1. Монгол улсын иргэн Бямбажав овогтой Ганбат

      1.1.2. Монгол улсын иргэн Баяраа овогтой Чойжилжалбуу

      1.1.3. Монгол улсын иргэн Билэгбадрах овогтой Энхтуяа

      1.1.4. Монгол улсын иргэн Лхагважав овогтой Гантөмөр

      1.1.5. Монгол улсын иргэн Мягмар овогтой Мөнхбаатар

      1.1.6. Монгол улсын иргэн Даваадорж овогтой Бадамчулуун

   1.2 Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр:

      1.2.1 Монгол улсын иргэн Дамбачүлтэм овогтой Байлыхүү

      1.2.2 Монгол улсын иргэн Энхбаяр овогтой Шижир

      1.2.3 Монгол улсын иргэн Чулуунцэрэн овогтой Отгочулуу

2. “МИК Холдинг” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн шинээр сонгогдсон ердийн болон хараат бус гишүүдийг Хувьцаа эзэмшигчид, Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид мэдэгдэхийг “МИК Холдинг” ХК-ийн Гүйцэтгэх захирал (Д.Гантөгс)-д даалгасугай.

3. Энэхүү Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн ажлын алба (Ж.Онон)-д даалгасугай.

MIK HOLDING
МИК ХОЛДИНГ ХК
1116216038 5221978
УЛААНБААТАР ХОТ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА М.МӨНХБААТАР

# “МИК ХОЛДИНГ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 4 сарын 28 өдөр | Дугаар № 17/03 | Улаанбаатар хот

*Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлын*
*2017 оны төсвийг батлах тухай*

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэг 62.1.15 дахь заалт, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, “МИК Холдинг” ХК-ийн ТУЗ-ийн нэр дэвшүүлэх шагнал урамшууллын хорооны 2017 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн хурлын дүгнэлтийг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны зардлын төсвийг Хавсралт 1-д заасны дагуу баталсугай.
2. Зардлын төсөвт хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нэр дэвшүүлэх цалин урамшууллын хорооны дарга (М.Мөнхбаатар)-д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА М.МӨНХБААТАР

MIK HOLDING
МИК ХОЛДИНГ ХК
1116210038 5221978
УЛААНБААТАР ХОТ

*2017 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн*
*Хувьцаа эзэмшигчдийн хурлын 17/03*
*тоот тогтоолын Хавсралт 1*

MIK HOLDING
МИК
ХОЛДИНГ
ХК
УЛААНБААТАР ХОТ

**"МИК Холдинг" ХК-ийн ТУЗ-ийн зардлын төсөв 2017/05/01-2018/04/30**

| Зардлын төрөл | Сарын цалин | Давтамж | Хүний тоо | Нийт | Үүнээс: | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 2017 | 2018 |
| **Цалин** | **5,125,000** | 12 | **15** | **292,500,000** | **195,000,000** | **97,500,000** |
| ТУЗ-ийн дарга | 2,750,000 | 12 | 1 | 33,000,000 | 22,000,000 | 11,000,000 |
| ТУЗ-ийн гишүүн | 2,000,000 | 12 | 8 | 192,000,000 | 128,000,000 | 64,000,000 |
| ТУЗ-ийн дэргэдэх хороодын гишүүд | 375,000 | 12 | 15 | 67,500,000 | 45,000,000 | 22,500,000 |
| **НДШ-ийн зардал** | | 12 | | **28,665,000** | **19,110,000** | **9,555,000** |
| **НИЙТ** | | | | **321,165,000** | **214,110,000** | **107,055,000** |

*Тайлбар*

"МИК Холдинг" ХК-ийн ТУЗ болон ТУЗ-ийн хороодын гишүүдийн сарын цалинг тухайн сард биечлэн болон онлайн байдлаар хуралд оролцсон бол олгох, /хэдэн удаа хуралдсанаас үл хамааран/ хэрэв хуралд оролцоогүй бол цалин олгохгүй болно.